



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/016

Булган

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан ахмадын амралтын замын засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дугаартай зөвлөмжийн дагуу дээрх ажлын гүйцэтгэгчээр “БУЛГАН АЗЗА” ТӨХК-тай 50000000 /тавин сая/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай.

2. Ахмадын амралтын замын засварын ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээг байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Гэрээний хугацаанд ахмадын амралтын замын засварын ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “БУЛГАН АЗЗА” ТӨХК /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

4. Тус ажлыг санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Авто замын сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ

